

**ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
-----	---	-------	------------------	--------------	-----------------	---	-------------------

Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.

1.1	Визийн зөвшөөрөл, иргэний харьялал, зөрчил шалган шийдвэрлэх асуудал хариуцсан нэгжийн болон байгууллагын бусад үйл ажиллагаа, үйлчилгээ, чиг үүрэгт хамаарах зөвлөгөө, мэдээллийг уригч аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэнд үнэн зөв, шуурхай хүргэх	Урсгал зардал	Иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо	85258	65000	<ul style="list-style-type: none"> -Зөвлөгөө, мэдээллийн хэлтсээс төвийн 6 шугам (201, 202, 207, 208, 209, 210), баруун (203), зүүн (204), өмнөд (205), хойд (206) бүс тус бүр 1 шугам, нийт 10 шугамаар дуудлага хүлээн авч нийт 50765 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс: - Виз, визийн зөвшөөрөлтэй холбоотой 24262; - Оршин суух зөвшөөрөлтэй холбоотой 21695; - Бусад буюу иргэний харьялал, зөрчил шалган шийдвэрлэлт, оршин суух үнэмлэхний хэвлэлт, олголт, Ф регистер, төлбөрийн буцаалт болон и-баримттай холбоотой, программын үйл ажиллагаа, гомдол, санал болон бусад асуудлаар 4808 иргэнд зөвлөгөө, мэдээллийг хүргэн ажиллав. <p>-Биечлэн 2708 иргэнд зөвлөгөө өгч ажилласнаас виз, визийн зөвшөөрлийн талаар 809, оршин суух зөвшөөрлийн талаар 732, бусад асуудлаар 884 иргэнд;</p> <p>-Цахим шуудангаар visasection@imigration.gov.mn 1203 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс Англи хэлээр 358, Монгол хэлээр 845 имэйл илгээсэн.</p>	100
-----	---	---------------	-------------------------------	-------	-------	---	-----

						-Байгууллагын фэйсбууц хуудасны мессенжер чатаар 180 иргэнд зөвлөгөө өгснөөс Монгол хэлээр 173, англи хэлээр 7 зөвлөгөөг өгч ажиллалаа.	
1.2	Монгол Улсаас гадаад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан хаагчдыг зөвлөгөө, мэдээллээр хангах	Урсгал зардал	Үйлчилгээ хүргэсэн тоо	2/65	2/10	Монгол Улсаас БНКаз.У, БНТурк.Улс, БНФранц.У, ИБУИНХУ, Тайландын Хаант Улс, Япон, БНХАУ-ын Эрээн, Хөх хот, ОХУ-ын Улаан-Үүдэд суугаа Элчин сайдын яам, консулын газрын ажилтнуудад 14 удаа зөвлөн, тусалж ажилласан.	100
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхийг бэжжүүлнэ.							
2.1	Зөвлөгөө, мэдээллийн үйл баримтлах батлуулах заавар	Урсгал зардал	Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд баримтлах заавар батлуулсан огноо, дугаар	-	1	Байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/101 дугаар тушаалаар "Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд баримтлах заавар"-ыг батлуулан мөн өдрийн 10/18 дугаар дотоод албан бичгээр төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжид хүргүүлэн ажиллав.	100
2.2	Зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 дугаарын утсаар хандсан нийт дуудлагад эзлэх алдсан дуудлагын хувийг бууруулах	Урсгал зардал	Нийт дуудлагад эзлэх алдсан дуудлагын хувийг бууруулах	13%	6.5%	Зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 дугаарын утсаар хандсан нийт 52629 дуудлагаас 50765 дуудлагад хариу өгч 1864 дуудлагыг алдсан байна. Нийт дуудлагад эзлэх алдсан дуудлага 3.5% болж буурсан.	100
2.3	Байгууллагын гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлэх, холбогдох арга хэмжээний биелэлтийг тайлагнах	Урсгал зардал	Хургуулсан төлөвлөгөөний санал, тайлангийн тоо	1/2	1/2	Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 01 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-06 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 санал хүргүүлэн, 5 биелэлтийг хугацаанд нь гарган өгч ажиллалаа.	90
2.4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах	Урсгал зардал	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, биелэлт	-	2	-Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд 01 дүгээр сарын 07-ны өдрийн 10/03 дугаар дотоод албан бичгээр ЗҮГ-т; -Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаар ирүүлсэн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд саналаа 01 дүгээр сарын 08-ны өдрийн 10/04 дугаар дотоод албан бичгээр ЗҮГ-т; -Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны хэрэгжилтийг 02 дугаар сарын 04-ний өдөр гарган ЗҮГ-ын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяад ерг.e-mongolia.mn төрийн удирдлагын нэгдсэн системээр;	90

						-Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд саналаа 03 дугаар сарын 11-ний өдрийн 10/19 дугаар дотоод албан бичгээр; -“Эрсдэлд сууринсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10/10 дугаар дотоод албан бичгээр ЗУГ-т тус тус хүргүүлэн ажилласан.	
2.5	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх.	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь	-	100	Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирсэн 4 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлсэн	90
2.6	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд түгээх	Урсгал зардал	Түгээсэн мэдээллийн тоо; Мэдээлэл түгээсэн цахим хуудасны тоо	1/12	1/12	-Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн танилцуулга болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг фэйсбуук хуудаст байршуулахаар 01 дүгээр сарын 20-ны өдөр ЗУГ-ын ахлах мэргэжилтэн Ч.Гантуяад хүргүүлсэн. -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 507 мэдээ, мэдээллийг фэйсбуукээр түгээсэн байна.	90
2.7	Албан хаагчдыг мэргшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад зөвлөн туслах	Урсгал зардал	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчийн тоо, зөвлөн тусалсан албан хаагчийн тоо	1/16/-	3/36/400	1. Байгууллагын даргын 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01-02/04 дугаар удирдамжийн дагуу сургалтыг 01 дүгээр сарын 20-24-ний өдөр зохион байгуулж, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн 2, Дорноговь аймаг дахь газрын 1,Өмнөд бүс дэх газрын 2, Хойд бүс дэх газрын 2, Баруун бүс дэх газрын 2, Зүүн бүс дэх газрын 2 нийт 11 албан хаагч хамрагдлаа. Сургалтад хамрагдсан албан хаагчдын сургалтын өмнөх болон дараах мэдлэгийг 2 удаагийн тест ажиллуулж үнэлхэхд дундаж оноо 61.4 хувиас 85.5 хувь болж ессөн үзүүлэлттэй дүгнэгдсэнийг 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01-02/06 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан ажилласан. 2. “Хас банк”-ны төв байранд 01 дүгээр сарын 08-ны өдөр гадаад харилцагч үйлчилгээний 10 албан хаагч;	70

						3. Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх албаны 04 дүгээр сарын 03-ны өдөр 25 сургач багш нарт; 4. Чингэлтэй дүүргийн Тамгын газарт 04 дүгээр сарын 22-ны өдөр 30 албан хаагч; 5. Зочид буудлын холбооны 38 аж ахуйн нэгжийн төлеөлөлд 06 дугаар сарын 06-ны өдөр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох журам, дүрмийн талаар сургалт зохион байгуулсан. 6. Байгууллагын даргын 05 дугаар сарын 19-ний өдрийн 10/01 дугаар удирдамжийн дагуу 05 дугаар сарын 22-ны өдөр 16:00-17:30 цагийн хооронд "Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний заавар", цахим үйлчилгээний түгээмэл асуултууд, анхаарах асуудлаар Зүүн бүс дэх газрын 9, Дорноговь аймаг дахь газрын 5, Өмнөд бүс дэх газрын 5, Баруун бүс дэх газрын 5, Хойд бүс дэх газрын 5, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 1 нийт 30 албан хаагчдад цахимаар сургалт зохион байгуулсан. Сургалтын талаар 05 дугаар сарын 26-ны өдрийн 10/08 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулсан.	
2.8	Нэгжийн албан хаагчдыг хөгжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	Зерчил шийдвэрлэлттэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөхөд анхаарах асуудлын талаар сургалт авахаар 05 дугаар сарын 22-ны өдрийн 10/25 дугаартай дотоод албан бичгийг Зерчил, шалган шийдвэрлэх газарт хүргүүлж, 06 дугаар сарын 06-ны өдрийн 10.00-11.30 цагт Зерчил, шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын байцааг Ч.Өсөхбаяр сургалт хийсэн.	100
Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.							
3.1	Хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан чатбот хөгжүүлэн зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлэх	Урсгал зардал	Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх	-	1	Хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан чатбот хөгжүүлэхэд зориулсан мэдээллийг цуглуулах буюу визийн ангилал, оршин суух төрөл, хэлбэр тус бүр дээр үйлдлүүдийн хувилбаруудыг боловсруулан, /гэр бүлийн, хувийн зорилгоор, цагаач/-13 ангилал, /хөдөлмөр эрхлэгч, шашны зорилгоор/-29 ангилал дээр мэдээлэл цуглуулж 06 дугаар сарын 06-ны	30

						өдрийн 10/27 дугаар дотоод албан бичгээр Мэдээлэл, технологийн хэлтэст хүргүүлсэн (Чатбот хөгжүүлэлтийн компанийтай гэрээ байгуулах эсэх асуудлыг Мэдээлэл, технологийн хэлтсээс судалж байгаа).	
3.2	Зөвлөгөө, мэдээллийн виртуал ажилтны дүрийг бий болгож, олон нийтийн сүлжээгээр дамжуулан видео зөвлөгөөг хүргэх	Урсгал зардал	Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх, зөвлөгөөний тоо	-	1/3	Удирдах ажилтны зөвлөгөөн дээр 02 дугаар сарын 03-ны өдөр хийсэн хэлтсийн танилцуулга дээр виртуал дүр болон мэргэжилтний зургаас авсан дүрээр олон хэл дээр мэдээлэл хүргэж, туршилт хийсэн. Байгууллагын даргын 05 дугаар сарын 26-ны өдрийн А/242 дугаар "Аян зохион байгуулах" тухай тушаалаар нөлөөллийн аяныг 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд хиймэл оюун ухаанаар үүсгэсэн дур бүхий видео зөвлөмжийг бүтээн ажиллаж байна.	70

Үнэлгээ: 85.8 хувь


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				
1	2	3	4	5	6	7			
1	Арга хэмжээ 1. Хувь хүний хөгжил, харилцааны ур чадварын сургалт	Сертификат	-	1	- БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-аас "Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Сөүл хотноо зохион байгуулж буй сургалтад хамрагдсан 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 18-ны өдрүүдэд хамрагдсан. - "Дэйл Карнеги Трэйнинг Монгол" төвийн "Хүчирхэг илтгэл" сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн. Сургалт 06 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд явагдана. Бүртгэлийн хуудсыг хавсаргав.	2025.01-12 дугаар сар	50		

2	Арга хэмжээ 2. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох "Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалт"-д хамрагдах	Сертификат	-	1	Хамрагдаж тэнцсэн.	2025.04-06 дугаар сар	100
Үнэлгээ: 75 хувь							

Төлөвлөгөөг үнэлсэн:
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг



Гэсэний шууд захирагч
/Н.УУГАНБАЯР/
(гарын үсэг)
(огноо).....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


Нэгжийн дарга



/З.ӨНӨРСАЙХАН/
(гарын үсэг)
(огноо).....
2025.06.18

Тайлагнасан:
ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА
(албан тушаал)

Нэгжийн дарга



/Ц.СОЛОНГО/
(гарын үсэг)
(огноо).....
2025.06.18.